

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 4 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

## ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ЭНГИЙН ХУВЬЦАА НЭМЖ ГАРГАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.1, 55 дугаар зүйлийн 55.2, 55.3, 76 дугаар зүйлийн 76.1, 76.1.4, 76.1.6, 87 дугаар зүйлийн 87.1.2 заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9.2.12.12, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны 2 сарын 21-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 06 дугаар тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэний дагуу компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх үүднээс Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг үндэслэн нэг бүр нь 19 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 134,953,581 ширхэг, энгийн хувьцааг, хаалттай хүрээнд нэмж гаргасугай.
2. Компанийн нэмж гаргаж буй хувьцаа нь компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохгүй тул хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх шаардлага үүсэхгүй болохыг дурдсугай.
3. Хаалттай хүрээнд энгийн хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан компанийн хөрөнгө нэмэгдэж, гаргасан хувьцааны тоонд өөрчлөлт орох тул тус өөрчлөлтийг компанийн дүрэмд тусган холбогдох газруудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Золжаргалд үүрэг болгосугай.
4. Япон улсын иргэн Шинтани Такаёши-тай байгуулах Хувьцаа худалдах, худалдан авах, эрх шилжүүлэх гэрээнд компанийг төлөөлөн компанийн Гүйцэтгэх захирал Б.Золжаргалд гарын үсэг зурах эрхийг олгосугай.
5. Нэмэлт хувьцааны Үнэт цаасны бүрдүүлбэрийг бэлтгэж, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Золжаргалд даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 4 өдөр

Дугаар №13

Улаанбаатар хот

## НЭМЖ ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХГҮЙ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8, 87 дугаар зүйлийн 87.1.2 заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны 2 сарын 21-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 06 дугаар тоот тогтоолыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэмэлт энгийн хувьцаа гаргах асуудлыг хэлэлцэн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дэмжигдэн шийдвэрлэсэн. Тус хэлэлцсэн асуудалд эсрэг саналтай хувьцаа эзэмшигч байгаагүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлд нэмж гаргах энгийн хувьцаатай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг өгсний дагуу, мөн хувьцааг худалдах үнийг тухайн хувьцааны сүүлийн 6 сарын арилжааны жигнэсэн дундаж ханшаас 10 хувиас бага үнээр тогтоогоогүй, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа гаргаагүй тул Тандэм Инвэст ББСБ ХК-ийн нэмж гаргаж буй 134,953,581 ширхэг хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг тус компанийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй



ТУЗ-ИЙН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ